



ХУРААНГУЙ НЭГТГЭСЭН ЗАВСРЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

(мянган Канад доллараар)
(Аудитаар баталгаажуулаагүй)

Удирдлага бэлтгэв

2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайланг аудитор хянан баталгаажуулаагүй тухай мэдэгдэл

Канад Улсын Үнэт цаасны зохицуулагчдын гаргасан NI 51-102 “Тасралтгүй мэдээлэх үүрэг” (National Instrument 51-102 Continuous Disclosure Obligations)-ийн 4 дүгээр хэсгийн 4.3(3)(a) дэд заалтын дагуу аудитор завсрын санхүүгийн тайланг хянан баталгаажуулалт хийгээгүй тохиолдолд тухайн завсрын санхүүгийн тайланд аудитор баталгаажуулалт хийгдээгүй болохыг мэдэгдсэн мэдэгдлийг хавсаргах шаардлагатай.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорацийн 2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон аудитаар баталгаажуулаагүй хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангуудыг Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлөөс баталсан Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 34 “Завсрын санхүүгийн тайлагнал” (IAS 34)-ын дагуу бэлтгэсэн бөгөөд энэхүү санхүүгийн тайланг бэлтгэх нь Компанийн удирдлагын хариуцлага болно.

Хараат бус аудитор MNP LLP нь энэхүү хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайланг хянан баталгаажуулаагүй болно.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн байдлын тайлан

(Мянган канад доллароор илэрхийлэв) – Аудитаар баталгаажуулаагүй

	Тодруулга	2026.06.30	2025.12.31
Хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		\$ 27,789	\$ 4,659
Дансны авлага		455	320
Урьдчилж төлсөн зардал		244	216
Эргэлтийн хөрөнгийн дүн		28,488	5,195
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	4	66,976	46,925
Хайгуул, үнэлгээний хөрөнгө	5	4,517	3,782
Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж		76	79
Ашиглах эрхийн хөрөнгө		73	86
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		71,642	50,872
Нийт хөрөнгийн дүн		\$ 100,130	\$ 56,067
Өр төлбөр			
Худалдаа болон бусад өглөг		\$ 462	\$ 1,444
Түрээсийн өр төлбөр		26	25
Богино хугацаат өр төлбөр		488	1,469
Түрээсийн өр төлбөр		51	64
Урт хугацаат өр төлбөр		51	64
Нийт өр төлбөрийн дүн		539	1,533
Эздийн өмч			
Хувьцаат капитал	6	\$ 199,000	\$ 170,721
Нэмж төлөгдсөн капитал	6	30,527	30,488
Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй орлого (алдагдал)		243	(1,739)
Алдагдал		(130,179)	(144,936)
Эздийн өмчийн дүн		99,591	54,534
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		\$ 100,130	\$ 56,067

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

Төлөөлөн Удирдах Зөвлөх ("ТУЗ")-ийг төлөөлж баталсан:

Гарын үсэг зурсан "Кеннет В.МакДоналд"

ТУЗ-ийн гишүүн

Гарын үсэг зурсан "Лэйтон Т.Крофт"

ТУЗ-ийн гишүүн

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын орлого (алдагдал) болон дэлгэрэнгүй орлого (алдагдал)-ын тайлан
(Мянган канад доллароор илэрхийлэв, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс
бусдаар) – Аудитаар баталгаажуулаагүй

	6.30-нд дуусгавар болсон гурван сар		6.30-нд дуусгавар болсон зургаан сар		
	Тодруулга	2026	2025	2026	2025
Үйл ажиллагааны зардал					
Хайгуул, үнэлгээний зардал	7	\$ (726)	\$ (514)	\$ (1,617)	\$ (1,488)
Ерөнхий ба удирдлагын зардал	8	(676)	(659)	(2,120)	(2,159)
Үйл ажиллагаанаас учирсан алдагдал		(1,402)	(1,173)	(3,737)	(3,647)
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын орлого (алдагдал)					
	4	11,201	(2,995)	18,164	(5,080)
Санхүүгийн орлого		200	50	338	106
Хүүгийн зардал		(2)	(1)	(4)	(1)
Гадаад валютын ханшийн зөрүүнээс гарсан ашиг (алдагдал)		(4)	(3)	(4)	(1)
Цэвэр орлого (алдагдал)		\$ 9,993	\$ (4,122)	\$ 14,757	\$ (8,623)
Бусад дэлгэрэнгүй орлого (алдагдал):					
Гадаад дахь охин компанийн хөрвүүлгээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү		61	(165)	95	(215)
Гадаад дахь хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын хөрвүүлгээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү	4	1,207	(3,506)	1,887	(813)
Бусад дэлгэрэнгүй орлого (алдагдал)		1,268	(3,671)	1,982	(1,028)
Нийт дэлгэрэнгүй орлого (алдагдал)		\$ 11,261	\$ (7,793)	\$ 16,739	\$ (9,651)
Нэгж хувьцаанд ногдох суурь орлого (алдагдал) ⁽¹⁾		\$ 0.15	\$ (0.07)	\$ 0.22	\$ (0.14)
Нэгж хувьцаанд ногдох шингэрүүлсэн ашиг (алдагдал) ⁽¹⁾		\$ 0.15	\$ (0.07)	\$ 0.22	\$ (0.14)

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг.

⁽¹⁾ Компани нь 2025 оны 9-р сард энгийн хувьцааг нэгтгэсэн бөгөөд энгийн хувьцааны тоог өмнөх хугацаанд буцаан тусган залруулсан. Дэлгэрэнгүй мэдээллийг Тайлбар 1-ээс үзнэ үү.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын өмчийн өөрчлөлтийн тайлан
(Мянган канад доллароор илэрхийлэв, нэгж хувьцаанд ногдох болон хувьцааны мэдээллээс бусад) – Аудитаар баталгаажуулаагүй

	Тодруулга	Хувьцааны тоо ⁽¹⁾	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй орлого (алдагдал)	Алдагдал	Нийт эздийн өмч
2026.01.01-ний байдлаар		61,874,216	\$ 170,721	\$ 30,488	\$ (1,739)	\$ (144,936)	\$ 54,534
Тайлант үеийн нийт дэлгэрэнгүй орлого							
Цэвэр орлого		-	-	-	-	14,757	14,757
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-	1,982	-	1,982
Хаалттай хүрээнд төвлөрүүлсэн, хувьцаа гаргасан	6	3,230,000	26,852	-	-	-	26,852
Хэрэгжүүлсэн опцион	6	402,509	1,299	(409)	-	-	890
ИОХЭ-ийн дагуу гаргасан энгийн хувьцаа	6	52,985	128	(128)	-	-	-
Хувьцаанд суурилсан урамшуулал	6	-	-	576	-	-	576
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл, гүйлгээ		3,685,494	28,279	39	-	-	28,318
2026.06.30-ны байдлаар		65,559,710	\$ 199,000	\$ 30,527	\$ 243	\$ (130,179)	\$ 99,591
2025.01.01-ний байдлаар		60,356,137	\$ 165,590	\$ 30,656	\$ 2,725	\$ (136,754)	\$ 62,217
Тайлант үеийн нийт дэлгэрэнгүй алдагдал							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(8,623)	(8,623)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	(1,028)	-	(1,028)
Хэрэгжүүлсэн опцион	6	602,500	2,023	(599)	-	-	1,424
Хувьцаанд суурилсан урамшуулал	6	-	-	1,259	-	-	1,259
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл, гүйлгээ		602,500	2,023	660	-	-	2,683
2025.06.30-ны байдлаар		60,958,637	\$ 167,613	\$ 31,316	\$ 1,697	\$ (145,377)	\$ 55,249

Дагалдах тодруулгууд нь хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

⁽¹⁾ Компани нь 2025 оны 9-р сард энгийн хувьцааг нэгтгэсэн бөгөөд энгийн хувьцааны тоог өмнөх хугацаанд буцаан тусган залруулсан. Дэлгэрэнгүй мэдээллийг Тайлбар 1-ээс үзнэ үү.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын мөнгөн гүйлгээний тайлан
(Мянган канад доллароор илэрхийлэв) – Аудитаар баталгаажуулаагүй

Тодруулга	6.30-нд дуусгавар болсон гурван сар		6.30-нд дуусгавар болсон зургаан сар	
	2026	2025	2026	2025
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:				
Цэвэр орлого (алдагдал)	\$ 9,993	\$ (4,122)	\$ 14,757	\$ (8,623)
Мөнгөн бус				
Элэгдэл	13	5	25	8
Хувьцаанд суурилсан урамшуулал	6 -	329	576	1,259
Санхүүгийн орлого	(200)	(50)	(338)	(106)
Мөнгөн гүйлгээнд хамаарахгүй гадаад валютын ханшийн зөрүү	4	3	4	1
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын (орлого) алдагдал	4 (11,201)	2,995	(18,164)	5,080
Үйл ажиллагааны мөнгөн бус ажлын капиталын өөрчлөлт				
Авлага	(417)	(310)	(135)	(341)
Урьдчилж төлсөн зардал	(83)	(172)	(28)	(184)
Худалдаа болон бусад өглөг	207	143	(982)	335
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(1,684)	(1,179)	(4,285)	(2,571)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Энгийн хувьцаа гаргалт	6 -	-	28,747	-
Энгийн хувьцаа гаргасан зардал	6 (8)	-	(1,895)	-
Опцион хэрэгжүүлснээс үүдсэн орлого	6 567	1,032	890	1,424
Түрээсийн өр төлбөрийн эргэн төлөлт	(6)	(2)	(12)	(2)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	553	1,030	27,730	1,422
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Хайгуул, үнэлгээний хөрөнгийн зардал	5 (390)	(255)	(648)	(377)
Үндсэн хөрөнгө, үйлдвэр тоног төхөөрөмжийн зардал	(4)	(10)	(7)	(7)
Хүлээн авсан хүү	200	50	338	106
Хөрөнгө оруулалалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(194)	(215)	(317)	(278)
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	4	(9)	2	(8)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт (бууралт)	(1,321)	(373)	23,130	(1,435)
Тайлант үеийн эхэн дэх мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	29,110	6,236	4,659	7,298
Тайлант үеийн эцэс дэх өнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	\$ 27,789	\$ 5,863	27,789	5,863

Дагалдах тодруулгууд нь хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн тодруулга

(өөрөөр заагаагүй тохиолдолд мянган канад доллароор илэрхийлэв) – Аудитаар баталгаажуулаагүй

2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

1. Үйл ажиллагааны тухай:

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” “Корпораци” эсвэл “Компани” гэх) нь Канад Улсад төвтөй, Монгол Улсад үнэт болон суурь металлын хайгуул, хөгжүүлэлтийн үйл ажиллагааг эрхэлдэг компани. Компанийн голлох төсөл нь хараат компани болох Эрдэнэ Монгол ХХК-ийн эзэмшдэг Монгол Улсын Баянхонгор аймагт орших Баянхөндий алтны төсөл юм. Компанийн үнэт цаас нь Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр “ERD”, Монголын Хөрөнгийн Бирж дээр “ERDN” тикертэйгээр арилжаалагддаг. Компанийн албан хаяг нь 1300-1969 Upper Water Street, Halifax, Nova Scotia, B3J 2V1.

2025 оны 6 сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, тусгай хурлаар компанийн гаргасан болон эргэлтэд байгаа 6 ширхэг энгийн хувьцааг 1 ширхэг хувьцаа болгон нэгтгэх шийдвэрийг баталсан. Энэхүү нэгтгэл нь 2025 оны 9 сарын 2-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон ба компанийн гаргасан болон эргэлтэд буй 366,351,958 энгийн хувьцааны тоо ширхэг нэгтгэлийн дараа 61,063,549 ширхэг болсон. Мөн опцион болон ирээдүйд олгогдох хувьцааны нэгжүүд (deferred share units)-ийг хувьцааны нэгтгэлийн харьцаанд нийцүүлэн тохируулсан. Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөлөөс гаргасан ОУНБС (IFRS®)-ын дагуу энэхүү өөрчлөлтийг өмнөх хугацаанд буцаан тусган тооцсон бөгөөд үүний үр дүнд хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлан болон холбогдох тайлбаруудад тусгагдсан энгийн хувьцааны мэдээлэл, нэгж хувьцаанд ногдох үзүүлэлтүүд болон хувьцааны опционтой холбоотой мэдээлэл нь, өөрөөр заагаагүй бол, тайлагнасан бүх хугацаанд энэхүү нэгтгэлийг тусган харуулсан болно.

2. Тайлангийн үндэслэл

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын аудитаар баталгаажуулаагүй хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайланг (“Хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлан”) Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (“НББОУС”) 34 - завсрын санхүүгийн тайлагналын дагуу боловсруулсан. Завсрын үеийн санхүүгийн тайлан нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НББОУСЗ”) -ийн гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”) -ын дагуу боловсруулагдсан 2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан (“Жилийн эцсийн санхүүгийн тайлан”) -тай хамтад нь танилцах шаардлагатай.

Хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайланг тайлагнахыг 2026 оны 8 дугаар сарын 12-ны өдөр ТУЗ зөвшөөрсөн.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд

Шинээр мөрдсөн болон нэмэлт өөрчлөлт орсон стандартууд

СТОУС 7 болон СТОУС 9 - Санхүүгийн хэрэглүүр болон тодруулга

2024 оны 5 сараас эхлэн НББОУСЗ (“IASB”) Санхүүгийн хэрэглүүрийн ангилал болон үнэлгээнд (СТОУС 7 болон СТОУС 9) нэмэлт өөрчлөлт оруулсан. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдээр СТОУС 9-ийн ангилал болон үнэлгээ, СТОУС 7-ийн холбогдох тодруулгын шаардлагыг шинэчилсэн. НББОУСЗ-өөс зарим санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, данснаас хасах огноог тодруулж, цахим төлбөрийн системийг ашиглан санхүүгийн өр төлбөрийг барагдуулахтай холбоотой шаардлагад өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлт нь 2026 оны 1 сарын 1 болон түүнээс хойш эхлэх жилийн тайлант үеүүдэд хүчин төгөлдөр болох ба энэхүү хугацаанаас өмнө даган мөрдөхийг зөвшөөрсөн. Компани нь дээрх стандартыг 2026 оны 1 сарын 1-ээс ирээдүйд мөрдөх зарчмаар хэрэглэсэн ба санхүүгийн тайланд нөлөө үзүүлээгүй.

Доорх стандартыг нягтлан бодох бүртгэлд мөрдөж эхлээгүй

СТОУС 18 – Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга

2024 оны 4 сарын 9-нд НББОУСЗ (“IASB”) нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгыг орлох СТОУС 18 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга танилцуулсан. СТОУС 18 нь ашиг алдагдлын тайланд ангилал, тодорхойлсон дэд нийлбэр нэмж, удирдлагын тодорхойлсон гүйцэтгэлийн хэмжүүрүүдийн тодруулга, санхүүгийн тайлангийн мэдээллийг нэгтгэх, задлахыг сайжруулах шаардлагыг

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн тодруулга
(өөрөөр заагаагүй тохиолдолд мянган канад доллароор илэрхийлэв) – Аудитаар баталгаажуулаагүй

2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд (үргэлжлэл)

тусгасан. СТОУС 18-ын хүрээнд НББОУС 7-д нэмэлт өөрчлөлт оруулсан ба аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны ашгийн дэд дүнг үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг шууд бус аргаар тайлагнах эхлэлийн үзүүлэлт болгон ашиглах, мөн төлсөн болон хүлээн авсан хүү, ногдол ашгийг толилуулах сонголтуудыг хасах шаардлагатай болсон. Үүнтэй адил НББОУС 33 “Нэгж хувьцаанд ногдох ашиг”-т нэмэлт өөрчлөлт оруулж, СТОУС 18-д нийт эсвэл дэд нийлбэрийн тоон үзүүлэлтээр ашиг, алдагдлын тайлангийн бусад бүрэлдэхүүн хэсгийг ашиглан нэгж хувьцаанд ногдох ашгийн нэмэлт мэдээллийг тодруулахыг зөвшөөрсөн. СТОУС 18 нь 2027 оны 1 сарын 1-ээс эхлэн тайлангийн үед хүчин төгөлдөр болох ба буцаан мөрдөх зарчмаар хэрэглэнэ. Компани нь дээрх стандартыг мөрдөж эхэлснээр санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг үнэлж байна.

4. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт

2023 оны 1 сарын 10-нд Компани нь Баянхөндий алтны төслийг хөгжүүлэх зорилгоор Монголиан Майнинг Корпорэйшн (“ММС”)–тэй стратегийн түншлэл болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсныг мэдээлсэн. Стратегийн түншлэлийн үндсэн нөхцөлүүдийг доор дурдав:

- ММС нь 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Хөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК (“ЭМ”)–ын 50%-тай тэнцэх хувьцаанд хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг гаргасан.
- Эрдэнэ Ресурс нь Эрдэнэ Монгол ХХК-ийн 50%-г эзэмшихээс гадна Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эхний 400,000 унц алтны олборлолтоос давсан олборлолт болон дээрх тусгай зөвшөөрлүүдийн хилээс 5 км-ийн дотор шинээр эзэмших тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд 5%-ийн боловсруулах үйлдвэрийн өгөөжийн роялти (“Net smelter return” буюу “NSR”) авах нөхцөлтэй.

2024 оны 1 сарын 23-нд хөрвөх нөхцөлтэй өрийн бичгийг хөрвүүлсэнтэй холбогдуулан Эрдэнэ Монгол ХХК нь 50%-тай тэнцэх хувьцааг нэмж гарган, ММС-г хувь эзэмшигчээр бүртгэсэн. Компани нь Эрдэнэ Монгол ХХК (“ЭМ”)–ийн засаглалд оролцон, нөлөө үзүүлэх эрхээ хадгалсаар байгаа боловч санхүүгийн тайлагналын чиг үүрэгт шууд оролцохоо больсон.

2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон нэг жил, 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд компанийн хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн хураангуйг доор харуулав.

	6 сарын 30 2026	12 сарын 31 2025
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт, тайлангийн эхэнд \$	46,925	\$ 53,110
Хараат компаниас орсон орлого	18,164	(1,918)
Гадаад валютын өөрчлөлтийн нөлөөлөл	1,887	(4,267)
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт, тайлангийн эцэст \$	66,976	\$ 46,925

Дараах хүснэгтүүдэд Эрдэнэ Монгол ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн мэдээллийг 100% сууриар хураангуйлан харуулсан бөгөөд өмчийн аргаар бүртгэх зорилгоор бодит үнэ цэнийн тохируулгыг тусгасан.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн тодруулга

(өөрөөр заагаагүй тохиолдолд мянган канад доллароор илэрхийлэв) – Аудитаар баталгаажуулаагүй

2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

4. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Хугацаанд	6 сарын 30 2026	12 сарын 31 2025
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах	\$ 55,953	\$ 18,325
Бусад эргэлтийн хөрөнгө	29,007	23,193
Эргэлтийн бус хөрөнгө	266,068	252,129
Богино хугацаат өр төлбөр	(32,659)	(90,949)
Урт хугацаат өр төлбөр	(184,417)	(108,848)
Цэвэр хөрөнгө	\$ 133,952	\$ 93,850

Хугацаанд	6 сарын 30 2026	6 сарын 30 2025
Орлого	\$ 130,378	\$ -
Борлуулалтын өртөг	(63,215)	-
Нийт ашиг	67,163	-
Цэвэр ашиг (алдагдал)	\$ 36,328	\$ (10,160)
Бусад дэлгэрэнгүй орлого (алдагдал)	-	-
Нийт дэлгэрэнгүй орлого (алдагдал)	\$ 36,328	\$ (10,160)

Эрдэнэ Монгол ХХК-ийн хураангуй санхүүгийн мэдээллийг Компанийн хөрөнгө оруулалтын дансны үнэтэй тулган нийцүүлсэн байдал:

Хугацаанд	6 сарын 30 2026	12 сарын 31 2025
Цэвэр хөрөнгө	\$ 133,952	\$ 93,850
Эрдэнэ Ресурсийн эзэмшлийн хувь	50.00%	50.00%
Компанийн эзэмшилд ногдох цэвэр хөрөнгө	\$ 66,976	\$ 46,925

5. Хайгуул, үнэлгээний хөрөнгө

Компанийн хайгуул болон үнэлгээний хөрөнгөд Монгол Улсад орших Зуун Мод болон Тэрэг Уул талбай багтдаг.

Компанийн 100% эзэмшлийн Зуун Мод төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт 6,041 га талбайг хамардаг бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайд молибден-зэсийн нөөц бүхий орд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд олгосон. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгодог ба 20 жилээр 2 удаа сунгах боломжтой. 2007 оны 7 сарын 1-ний өдөр Компани нь хангалттай үнэлгээ хийгдсэн гэж үзэн уг төслийн зардлыг капиталжуулж эхэлсэн. Иймд 2007 оны 7 сарын 1-ээс эхлэн энэхүү тайлангийн огноо хүртэл Зуун Мод төсөлтэй холбоотой бүх хайгуул болон үнэлгээний зардлыг капиталжуулж байна.

2025 оны 7 сарын 2-ны өдөр Компани нь Монгол Улсын Өмнөговь аймагт, Оюу Толгой ордоос баруун өмнө зүгт ойролцоогоор 10 км зайд байрлах Тэрэг Уул зэс-алтны порфирийн хэтийн төлөв бүхий талбайд 80 хүртэлх хувийн эзэмшлийг авах опцион гэрээг байгуулсан. Гэрээний нөхцөлийн дагуу Эрдэнэ Ресурс нь 12 сарын хугацаанд 300 мянган ам.долларыг хайгуулын зардалд зарцуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигч ("option grantor")-д 200 мянган ам.долларын төлбөр төлөх үүрэг хүлээнэ. Тус гэрээний нэг, хоёр болон гурав дахь жилийн ойд Компани нь 400; 500 болон 900 мянган ам.долларын төлбөрийг төлөх нөхцөлтэй бөгөөд нэмэлт 3 сая ам.долларын хайгуулын зардал гаргана.

Компани нь гэрээ зурагдсанаас хойш гурав болон дөрөв дэх жилийн хооронд тусгай зөвшөөрөл эзэмшигчид 3 сая ам.долларын төлбөрийг төлснөөр Тэрэг Уул Майнс ХХК-ийн 51%-ийг эзэмших эрхтэй болно.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн тодруулга

(өөрөөр заагаагүй тохиолдолд мянган канад доллароор илэрхийлэв) – Аудитаар баталгаажуулаагүй

2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

5 Хайгуул, үнэлгээний хөрөнгө (үргэлжлэл)

Эрдэнэ Ресурс нь нийт 10 сая ам.долларын хайгуул болон үнэлгээний зардал гаргаж, мөн нэмэлтээр 3 сая ам.долларын төлбөрийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлснөөр гэрээний найм дахь жилийн ойгоос өмнө 80 хүртэлх хувийн эзэмшлийг авах боломжтой. Дээрх төлбөрийг компанийн сонголтоор бэлэн мөнгө эсвэл хувьцаагаар төлөх боломжтой. Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд Эрдэнэ Ресурс нь бүх хайгуулын үйл ажиллагааг удирдан гүйцэтгэх бөгөөд аль ч хугацаанд торгуульгүйгээр гэрээг цуцлах эрхтэй. Тайлант хугацаа дууссаны дараа буюу 2026 оны 7 сарын 6-нд Компани эхний жилийн төлбөр болох 400 мянган ам.долларыг төлснөөр хугацааг дахин нэг жилээр сунгасан.

2026 оны 6 сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон зургаан сарын хугацаанд Компани нь эзэмшил олж авахтай холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлсөн аливаа төлбөрийг хайгуул, үнэлгээний хөрөнгөд капиталжуулаагүй (2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд: \$300). 2026 оны 6 сарын 30-ны байдлаар Компани нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу зардлыг капиталжуулж эхлэхэд шаардлагатай хангалттай үнэлгээг хараахан гүйцэтгээгүй тул 2026 оны 6 сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон зургаан хугацаанд Тэрэг Уул төсөлтэй холбоотой 274 долларын хайгуул болон үнэлгээний зардлыг зардалд бүртгэсэн (2025 онд: \$0).

2025 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жил болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд Компанийн хайгуул, үнэлгээний хөрөнгийн өөрчлөлтийн хураангуйг доор харуулав:

	2026.06.30	2025.12.31
1 сарын 1-ний байдлаар	3,782	2,468
Нэмэгдэл	648	1,499
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	87	(185)
	4,517	3,782

6. Хувьцаат капитал, нэмж төлөгдсөн капитал

2025 оны 9 сарын 2-нд Компани нь гаргасан болон эргэлтэд буй хувьцааг 6:1 харьцаатай нэгтгэсэн. Ингэснээр 6 ширхэг энгийн хувьцааг нэгтгэн, нэгтгэлийн дараа 1 ширхэг энгийн хувьцаа болсон. Энгийн хувьцаа, нэгж хувьцаанд ногдох үзүүлэлт болон хувьцааны опцион, ИОХЭ-тэй холбоотой бүх мэдээлэл нь тайлагнасан бүх хугацаанд энэхүү хувьцааны нэгтгэлийг тусган харуулсан болно.

Гаргах эрхтэй хувьцаа

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй.

Гаргасан

2026 оны 2 сарын 5-ны өдөр Компани хаалттай, тогтоосон үнээр худалдан авах баталгаа гаргасан (bought deal) санхүүжилтийн хүрээнд нэгж бүр нь 8.90 долларын үнэлгээ бүхий 3,230,000 ширхэг энгийн хувьцааг гаргаж, нийт 28,747 долларын санхүүжилт татан төвлөрүүлсэн. Энэхүү хаалттай санхүүжилтийн хүрээнд Paradigm Capital Inc. болон National Bank Financial Inc. компаниуд тэргүүлэх андеррайтераар, BMO Capital Markets оролцон ажилласан. Компани хувьцаа гаргахтай холбоотойгоор 1,895 долларын зардал гаргасан бөгөөд үүний үр дүнд цэвэр төвлөрүүлсэн санхүүжилтийн хэмжээ 26,852 доллар болсон.

Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр болон Залгамж халааны төлөвлөгөө

2023 оны 6 сарын 22-ны өдөр Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр” (“ХСУБХ” буюу “Omnibus plan”) баталж, 2026 оны 5 сарын 28-нд дахин баталсан. ХСУБХ нь опцион (“Опцион” буюу “Options”), хязгаарлалт бүхий хувьцааны нэгж (“ХБХН” буюу “RSUs”) гүйцэтгэлд суурилсан хувьцааны нэгж (“ГСХН” буюу “PSUs”) ирээдүйд олгогдох хувьцааны эрх (“ИОХЭ” буюу “DSUs”) зэрэг хувьцаанд суурилсан урамшууллыг харьцангуй уян хатан байдлаар компани болон охин компаниудын захирал зөвлөхүүд, ажилтнуудад олгон, урт хугацаанд тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлнэ.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн тодруулга
(өөрөөр заагаагүй тохиолдолд мянган канад доллароор илэрхийлэв) – Аудитаар баталгаажуулаагүй

2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

6 Хувьцаат капитал, нэмж төлөгдсөн капитал (үргэлжлэл)

ХСУБХ нь батлагдсанаар Залгамж халааны төлөвлөгөө болох хувьцаанд суурилсан опционы төлөвлөгөө, ИОХЭ-ийн төлөвлөгөөг орлоно. Тус төлөвлөгөөнүүдийн дагуу олгогдсон урамшуулал нь анх олгосон нөхцөлийн дагуу хүчин төгөлдөр хэвээр байна.

ХСУБХ нь хувьсах төлөвлөгөө бөгөөд тус хөтөлбөрийн дагуу олгосон энгийн хувьцааны тоо хэмжээ нь аль ч үед (Залгамж халааны төлөвлөгөөний дагуу хүчин төгөлдөр байгаа урамшууллын хамт) Компанийн гаргасан болон эргэлтэд буй энгийн хувьцааны нийт хэмжээний 10%-аас хэтрэхгүй байх ёстой.

Хувьцааны опцион

Компани нь хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр болон залгамж халааны төлөвлөгөөний дагуу Компанийн ТУЗ-ийн гишүүд, удирдлага, ажилтан албан тушаалтнуудад компанийн энгийн хувьцаа худалдан авах опционыг олгодог. Опционыг хэрэгжүүлэх, олгох нөхцөлүүдийг ТУЗ тодорхойлно. Опцион олгогдох үед нөхцөлийг өөрөөр заагаагүй бол олгосон өдрөөс эхлэн эзэмших эрх үүснэ.

2025, 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд хувьцааны опционд гарсан өөрчлөлтүүд:

	2026.06.30		2025.06.30	
	Опционы тоо	Жигнэсэн дундаж хэрэгжүүлэх үнэ	Опционы тоо	Жигнэсэн дундаж хэрэгжүүлэх үнэ
1 сарын 1-ний байдлаар	2,975,239	\$ 2.43	3,740,896	\$ 2.10
Олгосон	158,000	7.93	562,518	4.02
Хэрэгжүүлсэн	(402,509)	2.21	(602,520)	2.34
6 сарын 30-ны байдлаар	2,730,730	\$ 2.78	3,700,894	\$ 2.34
6 сарын 30-ны байдлаар хэрэгжүүлэх боломжтой	2,730,730	\$ 2.78	3,700,894	\$ 2.34

2025 болон 2026 онд олгосон бүх опцион нь олгосон даруйд эзэмших эрх үүссэн бөгөөд таван жилийн хугацаатай. Доорх хүснэгтэд 2025, 2026 оны 6 сарын 30-ны байдлаар хүчин төгөлдөр байгаа бүх хувьцааны опционы мэдээллийг харуулав.

Дуусах хугацаа	2026.06.30		2025.06.30	
	Опционы тоо	Хэрэгжүүлэх үнэ	Опционы тоо	Хэрэгжүүлэх үнэ
2025-08-27	-	-	237,504	2.94
2025-12-01	-	-	33,334	2.28
2026-06-23	-	-	419,175	2.22
2026-08-18	33,334	2.58	33,334	2.58
2027-08-09	389,374	1.86	574,181	1.86
2027-12-30	29,167	1.80	29,167	1.80
2028-05-09	791,671	2.16	928,344	2.16
2029-02-12	791,672	1.80	883,339	1.80
2030-02-03	395,840	3.60	437,509	3.60
2030-06-25	91,672	5.46	125,007	5.46
2030-09-24	50,000	8.19	-	-
2031-02-10	158,000	7.93	-	-
	2,730,730	\$ 2.78	3,700,894	\$ 2.34

2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд олгосон опцион бүрийн бодит үнэ цэнийг олгосон өдөр нь Блэк Шолсийн опционы үнэлгээний загвар болон жигнэсэн дундаж таамаглал ашиглан тооцсон:

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн тодруулга
(өөрөөр заагаагүй тохиолдолд мянган канад доллароор илэрхийлэв) – Аудитаар баталгаажуулаагүй

2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

6 Хувьцаат капитал, нэмж төлөгдсөн капитал (үргэлжлэл)

	2026.06.30 дуусгавар болсон 6 сар	2025.06.30 дуусгавар болсон 6 сар
Гаргах өдрийн хувьцааны үнэ	\$ 8.26	\$ 3.97
Хэрэгжүүлэх үнэ	\$ 7.93	\$ 4.02
Эрсдэлгүй хүүгийн түвшин	2.7%	2.6%
Хүлээгдсэн хугацаа	4.4 жил	4.3 жил
Хүлээгдсэн хэлбэлзэл	50%	53%
Хүлээгдсэн ногдол ашиг	0.0%	0.0%
Гаргах өдрийн зах зээлийн жигнэсэн дундаж үнэ	\$ 3.65	\$ 1.72

Хүлээгдэж буй хэлбэлзлийг хувьцааны ханшийн түүхэн дундаж хэлбэлзэл харгалзан тооцсон.

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон 6 сарын хугацаанд олгосон опционтой холбоотойгоор \$576 долларын зардлыг хувьцаанд суурилсан урамшууллын зардалд хүлээн зөвшөөрч, хайгуул, үнэлгээний зардал болон захиргааны зардалд тус тус багтаасан. (2025 – \$968)

Ирээдүйд олгогдох хувьцааны эрх ("DSU")

2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд Компани нь ирээдүйд олгогдох хувьцааны эрх олгоогүй (2025 – нэгж бүр нь \$4.38 үнэлгээ бүхий 66,849 ширхэг ИОХЭ олгосон). Бодит үнэ цэн нь \$0 (2025 – \$291) бүхий ИОХЭ нь Захиргаа, удирдлагын зардал болон хайгуул, үнэлгээний зардалд тусгагдсан.

ИОХЭ нь олгосон өдөр шууд эзэмших эрх үүсэх бөгөөд хөтөлбөрт хамрагдсан гишүүний дансанд түүнд олгосон ИОХЭ-ийг бүртгэнэ. Хөтөлбөрт хамрагдсан гишүүний ажил, албан тушаалын харилцаа дуусгавар болох, эсвэл нас барсан тохиолдолд Компани тухайн үеийн зах зээлийн үнээр тооцсон төлбөрийг Компанийн шийдвэрийн дагуу бэлэн мөнгөөр эсвэл хувьцаагаар олгоно. Төлбөрийн хэлбэрийг сонгох эрх нь Компанид байх бөгөөд бэлэн мөнгөөр барагдуулахгүй үед уг хөтөлбөрийг өмчийн хэрэгслээр барагдуулах гэж бүртгэдэг. 2023 оны 6 сарын 22-нд батлагдсан хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийн төлөвлөгөө дэх ИОХЭ-ийн нөхцөлүүд нь хуучин хэрэгжиж байсан ИОХЭ-ийн хөтөлбөрийн заалтуудтай нийцэж байна.

2025, 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын байдлаар ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн тухай мэдээлэл:

	2026.06.30	2025.06.30
	Тоо ширхэг	Тоо ширхэг
1 сарын 1-ний байдлаар	1,613,751	1,665,223
Олгосон	-	66,849
Гаргасан	(52,985)	-
6 сарын 30-ны байдлаар	1,560,766	1,732,072

Хязгаарлалт бүхий хувьцааны нэгж ("RSU")

Компанийн хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийн хүрээнд компанийн ажилтан, удирдах албан тушаалтан болон ТУЗ-ийн гишүүдэд хязгаарлалт бүхий хувьцааны нэгж ("RSU") олгох боломжтой. Хязгаарлалт бүхий хувьцааны нэгжийг хүлээн авсан оролцогч нь нэг энгийн хувьцаатай тэнцэх хэмжээний мөнгөн төлбөрийг авах эрхтэй болох бөгөөд тухайн ХБХН-ийн эзэмших эрх үүсэнээс хойш 30 хоногийн дотор олгоно. Хязгаарлалт бүхий хувьцааны нэгж нь ихэвчлэн олгогдсон өдрөөс хойш 3 жилийн хугацаанд үе шаттайгаар эзэмших эрх үүсэж, хэрэгжүүлэх боломжтой болдог бөгөөд олгосон өдрийн эхний, хоёр дахь болон гурав дахь жилийн ой бүрт нийт олгогдсон хязгаарлалт бүхий хувьцааны нэгжийн гуравны нэг (1/3) нь хэрэгжиж эхэлнэ. Энэхүү төлөвлөгөөг мөнгөн төлбөрөөр барагдуулах хувьцаанд суурилсан төлбөрийн төлөвлөгөө гэж бүртгэнэ. Үүний дүнд \$181 (2025 – \$0)-ын өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн ба уг дүнг худалдаа, бусад өглөгт тусгасан. Энэхүү өр төлбөрийг 2026 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар компанийн нэг энгийн хувьцааны зах зээлийн хаалтын ханш болох \$5.26-т үндэслэн тооцсон.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн тодруулга

(өөрөөр заагаагүй тохиолдолд мянган канад доллароор илэрхийлэв) – Аудитаар баталгаажуулаагүй

2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

6 Хувьцаат капитал, нэмж төлөгдсөн капитал (үргэлжлэл)

2025, 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд хязгаарлалт бүхий хувьцааны нэгжийн өөрчлөлтийг дараах хүснэгтэд хураангуйлан харуулав:

	2026.06.30	2025.06.30
	Тоо ширхэг	Тоо ширхэг
1 сарын 1-ний байдлаар	-	-
Олгосон	129,000	-
6 сарын 30-ны байдлаар	129,000	-

Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)

Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)-ыг тухайн тайлант хугацаанд эргэлтэд байсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо болон хувьцаагаар барагдуулахаар хүлээгдэж буй, эзэмших эрх нь үүссэн ирээдүйд олгогдох хувьцааны нэгж (DSU)-ийн жигнэсэн дундаж тоонд үндэслэн тооцдог. Шингэрүүлсэн нэгж хувьцаанд ногдох цэвэр ашгийг опционыг тайлант хугацааны эхлэл эсвэл олгосон өдөр (аль нь хожуу өдрөөр)-ийн байдлаар хэрэгжүүлсэн гэх таамаглалд үндэслэн тооцдог. 2026 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар 208,000 ширхэг опцион (2025 он – 3,700,894 ширхэг опцион)-ыг шингэрүүлэхийн эсрэг нөлөөтэй тул хувьцаанд ногдох шингэрүүлсэн цэвэр ашиг (алдагдал)-ын тооцоонд оруулаагүй.

Дараах хүснэгтэд эргэлтэд байгаа хувьцааны жигнэсэн дундаж тоог шингэрүүлсэн жигнэсэн дундаж хувьцааны тоотой тулган нийцүүлснийг харуулав.

	6.30-нд дуусгавар болсон гурван сар		6.30-нд дуусгавар болсон зургаан сар	
	2026	2025	2026	2025
Эргэлтэд байгаа энгийн хувьцаа болон эрх нь үүссэн ИОХЭ-ийн жигнэсэн дундаж тоо	66,926,685	62,549,195	66,196,374	62,352,759
Эргэлтэд байгаа, хэрэгжүүлэх боломжтой опционы шингэрүүлэх нөлөө	1,678,232	-	1,678,232	-
Шингэрүүлсэн эргэлтэд байгаа энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо	68,604,917	62,549,195	67,874,606	62,352,759

7. Хайгуул болон үнэлгээний зардал

2025, 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав ба зургаан сарын хугацаанд хайгуул болон үнэлгээний зардлыг дараах хүснэгтэд хураангуйлан харуулав:

	6.30-нд дуусгавар болсон гурван сар		6.30-нд дуусгавар болсон зургаан сар	
	2026	2025	2026	2025
Шууд зардал	\$ 712	\$ 163	\$ 877	\$ 274
Ажилтнуудын урамшуулал	381	407	1,165	1,248
Хувьцаанд суурилсан урамшуулал	55	241	411	571
Хараат компаниас нөхөн төлсөн	(422)	(297)	(836)	(605)
	\$ 726	\$ 514	\$ 1,617	\$ 1,488

Компанийн хараат компани Эрдэнэ Монгол ХХК нь геологийн үйлчилгээ үзүүлсний төлбөрт компанид жилд 1.375 сая ам.доллар (2025 он – жилд 1 сая ам.доллар)-ыг, холбогдох суутган төлөх татварыг хассан дүнгээр нөхөн төлөхөөр тохиролцсон.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн тодруулга
(өөрөөр заагаагүй тохиолдолд мянган канад доллароор илэрхийлэв) – Аудитаар баталгаажуулаагүй

2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

8. Захиргаа, удирдлагын зардал

2025, 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын хугацаанд захиргаа, удирдлагын зардлын мэдээллийг дор харуулав:

	6.30-нд дуусгавар болсон гурван сар 2026		6.30-нд дуусгавар болсон зургаан сар 2025	
Захиргааны үйлчилгээ	\$	210	\$	802
Хөрөнгө оруулагчтай харилцах, маркетинг		92		133
Оффис ба бусад		49		62
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр		97		212
Зохицуулагч байгууллага болон ТУЗ		137		191
Хувьцаанд суурилсан урамшуулал		50		688
Томилолтын зардал		41		71
	\$	676	\$	2,159

9. Санхүүгийн хэрэгслүүд

Зээлийн эрсдэл:

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь зээлийн эрсдэлийн хамгийн их өртөлтийг илэрхийлнэ. Тайлангийн өдрөөр зээлийн эрсдэлийн хамгийн их өртөлтийг доор харуулав:

	Дансны дүн	
	6 сарын 30 2026	12 сарын 31 2025
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах	\$ 27,789	\$ 4,659
Авлага	455	320
	\$ 28,244	\$ 4,979

Компани нь өөрийн бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн дийлэнх хэсгийг Канад дахь өндөр зэрэглэлтэй санхүүгийн байгууллагуудад байршуулж зээлийн эрсдэлийг удирддаг бөгөөд удирдлагын зүгээс алдагдал хүлээх эрсдэл бага гэж үздэг. 2026 оны 6 сарын 30-ны байдлаар \$126 доллар буюу бэлэн мөнгөний 1% нь Канадаас бусад банкнуудад хадгалагдаж байсан (2025.12.31 - \$159 доллар буюу 3%).

Хөрвөх чадварын эрсдэл:

Компанийн хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь мөнгө эсвэл бусад санхүүгийн хөрөнгө шилжүүлэх замаар барагдуулах санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргээ биелүүлэхэд Компани хүндрэлтэй тулгарах эрсдэлийг хэлнэ. Компани нь хөрвөх чадварын эрсдэлийг удирдахдаа хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд өр төлбөрийг хугацаанд нь барагдуулахад хүрэлцэхүйц хөрвөх чадвартай байхыг хангах бодлого баримталдаг. Компанийн бүх санхүүгийн өр төлбөрийг ирэх арван хоёр сарын дотор барагдуулахаар хүлээгдэж байна.

Зах зээлийн эрсдэл:

Зах зээлийн эрсдэл нь үнэт цаасны ханш, таваарын зах зээл, валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөөс үүдэн алдагдал хүлээх эрсдэлийг хэлнэ.

а) Хүүгийн эрсдэл

Компани нь илүүдэл бэлэн мөнгийг хүүгийн орлого бүхий хадгаламжийн дансанд байршуулж байгаа нь хүүгийн эрсдэлд өртөх магадлалтай.

б) Гадаад валютын эрсдэл

Компанийн үйл ажиллагааны валют нь канад доллар бөгөөд охин, хараат компанийн үйл ажиллагааны валют нь монгол төгрөг юм. Түүнээс гадна, Компани нь америк доллароор зардал гаргадаг.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корп. | Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлан |

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн тодруулга

(өөрөөр заагаагүй тохиолдолд мянган канад доллароор илэрхийлэв) – Аудитаар баталгаажуулаагүй

2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

9 Санхүүгийн хэрэгслүүд

Иймээс канад долларын бусад валюттай харьцах хэлбэлзэл нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Валютын хөрвөх эрсдэл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдэд ам.доллароор илэрхийлэгдэх бэлэн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, худалдаа болон бусад өглөг багтаж байна.

Компанийн гадаад валют (ам.доллар)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

	6 сарын 30 2026	12 сарын 31 2025
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 136	\$ 195
Авлага	424	297
Худалдаа, бусад өглөг	(42)	(33)
	\$ 518	\$ 459

Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь цэвэр алдагдал болон бусад дэлгэрэнгүй алдагдал (орлого), мөн хуримтлагдсан алдагдалд \$52 долларын нөлөө үзүүлэх магадлалтай (2025.12.31 - \$46).

Компанийн гадаад валют (монгол төгрөг)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

	6 сарын 30 2026	12 сарын 31 2025
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 12	\$ 22
Авлага	15	18
Худалдаа, бусад өглөг	-	(16)
	\$ 27	\$ 24

Төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь цэвэр алдагдал болон бусад дэлгэрэнгүй алдагдал (орлого), мөн хуримтлагдсан алдагдалд ойролцоогоор \$3 долларын нөлөө үзүүлэх магадлалтай (2025.12.31 - \$2).

с) Үнийн эрсдэл

Компанийн санхүүгийн хэрэгслүүд нь үнийн шууд эрсдэлд өртдөггүй.

Бодит үнэ цэн:

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр хэмжсэн, эсвэл санхүүгийн тайлангийн тодруулгад мэдээлсэн хөрөнгө болон өр төлбөрийг бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан өгөгдлийн ач холбогдлыг тусгасан бодит үнэ цэнийн шатлалын дагуу ангилна. Үүнд:

- Түвшин 1: Идэвхтэй зах зээл дэх ижил хөрөнгө эсвэл өр төлбөрийн үнийн санал (тохируулаагүй)
- Түвшин 2: Түвшин 1-д багтсан үнийн саналаас бусад, тухайн хөрөнгө эсвэл өр төлбөрийн хувьд шууд (жишээлбэл, үнэ хэлбэрээр) эсвэл шууд бусаар (жишээлбэл, үнээс үүсгэсэн) ажиглах боломжтой өгөгдөл;
- Түвшин 3: Тухайн хөрөнгө эсвэл өр төлбөрийн хувьд ажиглах боломжтой зах зээлийн өгөгдөлд үндэслээгүй буюу ажиглагдахгүй өгөгдөл.

Эдгээр санхүүгийн хэрэгслүүдийн төлөгдөх хугацаа богино тул санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэн нь тэдгээрийн дансны үнэтэй ойролцоо байна.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн тодруулга
(өөрөөр заагаагүй тохиолдолд мянган канад доллароор илэрхийлэв) – Аудитаар баталгаажуулаагүй

2025 болон 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

10. Холбогдох талууд

Компанийн гол удирдах албан тушаалтнууд болон ТУЗ-ийн гишүүдэд олгосон нийт цалин, урамшууллыг доор харуулав:

	6.30-нд дуусгавар болсон зургаан сар	
	2026	2025
ТУЗ-ийн гишүүдийн урамшуулал	\$ 123	\$ 60
Хувьцаанд суурилсан урамшуулал - ТУЗ	122	307
Ажилтнуудын цалин, урамшуулал	2,092	1,172
Удирдах албан тушаалтнуудын хувьцаанд суурилсан ур	318	427
	\$ 2,655	\$ 1,966

2026 оны 6 сарын 30 болон 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Компанийн удирдах албан тушаалтнууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон тэдгээрийн хяналтанд байдаг компаниудад төлөх ямар нэгэн өр төлбөр байхгүй.

Орчуулга: Энэхүү тайлан нь англи хэл дээр бэлтгэгдсэн тайлангийн орчуулга болно. Англи болон монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчил гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.